

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дүгээр сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

### **ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах тогтолцоог бурдүүлэх, мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж**

2.1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын хэвлэлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бутээгдэхүүний тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бурдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

#### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийг нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцаанд хамаарна.

3.2. Энэ хууль нь эрдэс баялгийн салбарын мэдээллийн санд түшиглэн эрдэс баялгийн салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, орлого, үр өгөөж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний зарчмыг тодорхойлох, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх болон эрдэс баялгийн салбарын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, эрх зүйн байдалтай холбогдсон харилцаанд хамаарна.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “анхан шатны тайлан” гэж энэ хуульд заасан журмын дагуу энэ хуулийн 14.1-т заасан этгээдийн гаргах тайланг;

4.1.2. “анхан шатны тайлан гаргах үүрэг бүхий хуулийн этгээд” гэж энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-т заасан ашигт малтмал хайх, ашиглах, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээдийг;

4.1.3. “бүтцийн зураглал” гэж хуулийн этгээдийн өмчлөлийн хэлхээ холбоог дүрсжүүлэн харуулсан, компанийг шууд болон шууд бус байдлаар удирдан чиглүүлэх эрх бүхий, эцэст нь ашиг хүртэгч, хувьцаа эзэмшигч этгээдийн бүтэн нэр, хуулийн этгээдийн хэлбэр, харьялагдах улс, эзэмшлийн хувь болон шийдвэрт нөлөөлөх хэлбэр, холбогдох бүртгэлийн дугаар зэргийг харуулсан зураглалыг;

4.1.4. “иргэний нийгмийн эвсэл” гэж эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах зорилгоор төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулдаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын нэгдлийг;

4.1.5. “мэдээллийн сан” гэж ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах зэрэг үйлдвэрлэл эрхлэх болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой цогц үйл ажиллагааны мэдээллийг агуулсан эрдэс баялгийн салбарын мэдээллийн цахим санг,

4.1.6. “нэгдсэн тайлан” гэж энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан, хөндлөнгийн, хяналт хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн хянаж нэгтгэсэн, Үндэсний зөвлөлөөс батлан гаргах тайланг;

4.1.7. “олон нийтийн хяналт” гэж эрдэс баялгийн салбарт хууль тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт, эрдэс баялгийн салбарын хуулийн этгээдийн хариуцлагыг хянаж сайжруулах, салбарын болон төсвийн зохистой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бурдүүлэхэд хувь нэмэр үзүүлэхэд чиглэгдсэн иргэд, хуулийн этгээдийн хөндлөнгөөс тавих хяналтыг;

4.1.8. “олборлох үйлдвэрлэл” гэж ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой цогц үйл ажиллагааг;

4.1.9. “тайлан нэгтгэгч” гэж эрдэс баялгийн салбарын ил тод байдлын анхан шатны тайланг нэгтгэж нэгдсэн тайлан гаргах үүрэг бүхий, энэ хуулийн 24.1-д зааснаар эрх олгогдсон хуулийн этгээдийг;

- 4.1.10.“татварын бус төлбөр” гэж тайлан гаргагч хуулийн этгээдээс Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан орлого болон энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а, 11.1.3.в-д заасан гэрээтэй холбоотой төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг, торгууль, алданги, хандив, тусламж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зэрэг гэрээний дагуу төрийн холбогдох байгууллагад төлсөн төлбөрийг;
- 4.1.11.“төлбөр” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.36-д заасныг;
- 4.1.12.“орлого” гэж Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан төсөвт төвлөрүүлэх орлогыг;
- 4.1.13.“тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18-д заасан эрдэс баялгийг хайх, ашиглах, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон дээрх зорилгоор төрийн байгууллагатай гэрээ байгуулсан хуулийн этгээдийг;
- 4.1.14.“төсөл” гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;
- 4.1.14.а.нэг гэрээ, лиценз, концесс эсвэл тэдгээртэй ижил төстэй, харилцан хамаарал бүхий багц гэрээ хэлэлцээрээр зохицуулагддаг, тухайн хуулийн этгээдийн төртэй хийх төлбөрийн үүрэг хариуцлагын үндсийг бүрдүүлэх үйл ажиллагааг нэг төсөл гэж;
- 4.1.14.б.нэг хуулийн этгээд хэд хэдэн тусгай зөвшөөрөл эзэмшдэг, эсхүл нэг гэрээ буюу хөрөнгө оруулалтын болон бүтээгдэхүүн хуваах гэрээ, татварын хувь хэмжээг тогтвортжуулах гэрчилгээний хүрээнд хэрэгжиж буй, эсхүл нэг орд газарт хамаарах, газар зүйн байршлын хувьд зэрэгцээ талбайд орших, нэг техник-эдийн засгийн үндэслэлийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг нэг төсөл гэж;
- 4.1.15.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 2.1-т заасан этгээдийг;
- 4.1.16.“хураамж” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.40-д заасныг;
- 4.1.17.“хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.41-т заасан нөхцөл байдлыг;
- 4.1.18.“эрдэс баялаг” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан эрдсийн хуримтлалаас гадна Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.5 дахь хэсэгт заасан газрын тос, Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан цацраг идэвхт ашигт малтмал болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмалыг;
- 4.1.19.“эрдэс баялгийн салбар” гэж гэж ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг;
- 4.1.20.“эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасныг ойлгоно.

#### **5 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын зарчим**

- 5.1.Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
- 5.1.1.хууль дээдлэх;
- 5.1.2.иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, эрх тэгш, шударга өрсөлдөөнийг дэмжих;
- 5.1.3.эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх;
- 5.1.4.төрийн зохицуулалтын бүртгэл, зөвшөөрөл, хяналтын үйл ажиллагаа зохистой байх;
- 5.1.5.эрдэс баялгийн салбарын үр өгөөжийг оновчтой хуваарилах, төрийн бодлого боловсруулахад эрдэс баялгийн салбарын мэдээллээр хангах үйл ажиллагаанд цогц, шуурхай, үр дүнтэй дэмжлэг үзүүлэх;
- 5.1.6.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл олон нийтийн хяналт хэрэгжүүлэхэд нээлттэй байх;
- 5.1.7.иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагын мэдээллийн зөрүүг арилгах, харилцан ойлголцлыг дэмжих;
- 5.1.8.ил тод байдлыг хэрэгжүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хуулийн этгээд тэгш, чөлөөтэй, үр нөлөөтэй хамтран ажиллах;
- 5.1.9.ёс зүй, уламжлалыг хүндэтгэх.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ИЛ ТОД БАЙДЛЫГ**

**ХАНГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**

**ЭРХ ХЭМЖЭЭ, ЧИГ ҮҮРЭГ**

**6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1.Улсын Их Хурал эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.эрдэс баялгийн салбарын эрх зүйн зохицуулалт, мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаарх Үндэсний зөвлөлийн тайланг жил бүрийн 2 дугаар улиралд багтаан хэлэлцэх;

6.1.2.Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүр авч хэлэлцэнэ.

### **7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Засгийн газар улсын хэмжээнд эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар төрийн болон аж ахуйн нэгжийн мэдээллийн уялдааг хангах үйл ажиллагааг зохицуулж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх;

7.1.2.Үндэсний зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг томилох;

7.1.3.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын мэдээллийг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах;

7.1.4.эрдэс баялгийн салбарт төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээдийн зүгээс төрийн байгууллагатай байгуулсан гэрээний ил тод байдлыг хангах журам батлах;

7.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, тэдгээрийн улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамаарал бүхий байдлыг тодорхойлох, ил тод болгох журам батлах.

### **8 дугаар зүйл.Төрийн байгууллагын нийтлэг бүрэн эрх**

8.1.Энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.4-т заасан анхан шатны тайлан гаргах үүрэг хүлээсэн төрийн байгууллага, Засгийн газрын тусгай сангийн удирдлага хэрэгжүүлэх этгээд нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах хүрээнд дор дурдсан нийтлэг эрх хэмжээтэй байна:

8.1.1.эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн санд анхан шатны тайлан гаргагчаар бүртгүүлэх;

8.1.2.энэ хуульд заасан журмын дагуу ил тод байдлын тайланг энэ хуульд заасан хугацаанд холбогдох маягтын дагуу гаргах;

8.1.3.анхан шатны тайланг гаргахдаа шаардлагатай тайлбар, тодруулгыг өгөх, холбогдох материалыг хавсаргах;

8.1.4.Үндэсний зөвлөл, түүний ажлын алба болон тайлан нэгтгэгчээс тавьсан тодруулгын хариуг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргах, шаардлагатай мэдээллийг харьяа байгууллагаас гаргуулах;

8.1.5.анхан шатны тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа, тодруулга, мэдээллийг тайлан нэгтгэгч, Үндэсний зөвлөл, ажлын албанаас авах хүсэлт гаргах, уг туслалцааг үнэ төлбөргүй авах;

8.1.6.нэгдсэн тайлангийн хувийг авах, уг тайланг үйл ажиллагаандaa ашиглах;

8.1.7.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр, хэрэглэгчдэд ойлгомжтой байдааар олон нийтэд тогтмол мэдээлэх.

### **9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

9.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэх;

9.1.2.эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх;

9.1.3.эрдэс баялгийн салбарыг зохицуулах хууль тогтоомж, дүрэм, журам болон холбогдох төрийн байгууллагуудын хариуцах ажлын чиг үүрэг, олон улсын туршлагын талаарх мэдээлэл, өөрчлөлтийг цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.1.4.салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөөц боломж, үйлдвэрлэл, төсөл, хөтөлбөрийн талаар цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.1.5.эрдэс баялгийн салбарын мэдээллийн санг ашиглах, хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах журам батлах;

9.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.төсвийн бодлого, эрдэс баялгийн салбарын төвлөрүүлсэн орлого, татвар, хураамж, төлбөр, тухайн татвар, төлбөр, хураамжаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд эсвэл шууд шилжүүлсэн төсвийн хуваарилалт, тооцоололд ашиглах аргачлал зэргийг цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.2.2.эрдэс баялгийн салбарын төрийн болон орон нутгийн өмчйт, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын гуравдагч этгээдээс авсан зээл, зээлийн баталгаа, батлан даалтын мэдээлэл, улсын төсвөөс авсан хөнгөлөлт, татаасын талаар цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.2.3.төрийн болон орон нутгийн өмчйт, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага болон засгийн газрын санхүүгийн харилцааны талаарх мэдээллийг цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.2.4.эрдэс баялгийн салбараас бүрдүүлсэн төсвийн бус орлогыг эх үүсвэрээр ангилан цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

*Тайлбар:* энэ хуулийн 9.2.3-т заасан “санхүүгийн харилцаа” гэж төрийн болон төрийн өмчийн компани, төрийн өмчтөгийн газрын хооронд хийгдсэн мөнгөн болон мөнгөн бус шилжүүлэг, холбогдох шийдвэрийг ойлгоно.

9.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.3.1.тодорхой бус нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлэх, хэрэгжүүлж байгаа төсөлд хийсэн байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан, эрдэс баялгийн салбарын төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг хуулийн этгээдийн жагсаалтын хамт цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.3.2.харьяа байгууллагаас аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийг авч нэгтгэн цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.3.3.гадаргын болон гүний ус ашиглалт, дахин ашигласан усны хэмжээ, орон нутгийн байгаль орчин, экологи, ан амьтан, ургамал зүйл үзүүлэх нөлөөлөл, байгаль орчны нөхөн сэргээлт, барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын мэдээллийг төсөл бүрээр цахимаар нийтэл тогтмол мэдээлэх.

9.3.4.ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө, холбогдох тайлангийн ил тод байдлыг хангах журам батлах.

9.4.Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.4.1.эрдэс баялгийн салбарын нийгмийн стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан, эрдэс баялгийн салбарын төслийн нийгмийн нөлөөллийн төлөв байдал болон нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан, холбогдох менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг, дагалдах бичиг баримт, хуулийн этгээдийн мэдээллийн жагсаалтын хамт цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;

9.4.2.эрдэс баялгийн салбарын жендерийн нарийвчилсан болон нэгтгэсэн мэдээллийг өөрчлөлтийн хамт нийтэд тогтмол мэдээлэх.

## 10 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

10.1.Геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр, үйлчилгээний хураамж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой орлогыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд тус бүрээр нийтэд цахимаар тогтмол мэдээлэх;

10.1.2.эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулахад дэмжлэг үзүүлэх;

10.1.3.эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн сангийн мэдээллийг төрийн холбогдох байгууллагын мэдээлэлтэй тогтмол тулгалт хийж, зөрүүг холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлж, харилцан баталгаажуулах.

*Тайлбар:* “тухай бүр мэдээлэх” гэж хугацааг тусгайлан өөрөөр заагаагүй бол мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын З хоногийн дотор мэдээлэхийг хэлнэ.

10.2.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээллийн санг бүрдүүлэх;

10.2.2.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээллийн санг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан, улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай уялдуулах, олон нийтэд ил тод мэдээлэх нээлттэй мэдээллийн санд холбох, тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулах;

10.2.3.улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн сангийн мэдээлэлтэй тогтмол хугацаанд тулгалт хийж баталгаажуулах, мэдээллийн зөрүүг холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлж, харилцан баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх;

10.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамжийн орлогыг ашигт малтмалын төрөл, хуулийн этгээд, төсөл тус бүрээр нийтэд цахимаар тогтмол мэдээлэх;

10.3.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд эсхүл эцсийн эзэмшигч солигдсон, тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь шилжүүлсэн, худалдан борлуулснаас төсөвт төвлөрсөн татвар, холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх, нийтэд нээлттэй болгож, олон нийт судлах, эрэн сурвалжлах боломж нөхцөлийг бий болгох, мэдээллийн бусад сантай уялдуулах.

10.4.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 10.4.1.экспортын биет хэмжээ болон бүтээгдэхүүний нэгж үнэ, татвар, хураамжийн орлогыг ашигт малтмалын төрөл, гарал үүсэл, хуулийн этгээд, төсөл тус бүрээр мэдээлэх;
- 10.4.2.ашигт малтмал, бүтээгдэхүүн экспортлох улс, хүлээн авагч улс, хуулийн этгээдийн мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн бусад сантай уялдуулах.
- 10.5.Газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 10.5.1.эрдэс баялгийн салбарт газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн жагсаалт, газар ашиглах, эзэмших гэрээний жагсаалт, гэрээний мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх, мэдээллийн бусад сантай уялдуулах, цахимаар нийтэд тогтмол мэдээлэх.
- 10.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 10.6.1.эрдэс баялгийн салбарын төрийн өмчийн компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, үүрэг хариуцлага, бодлого, шийдвэрийн өөрчлөлтийн мэдээллийг цахимаар нийтэд тогтмол мэдээлэх;
- 10.6.2.эрдэс баялгийн салбарын төрийн өмчийн компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын хуримтлуулсан ашиг, хөрөнгө оруулалт, ногдол ашиг ба хуваарилалт, гуравдагч талын санхүүжилт, зээл зэрэгт хамаарах дүрэм журмыг мэдээлэх;
- 10.6.3.эрдэс баялгийн салбарын төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх шийдвэр, контракт, дүгнэлт, төрийн өмчийг захиран зарцуулахад олгогдсон эрх зэргийг нийтэд тогтмол шинэчлэн мэдээлнэ.
- 10.7.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан мэргэжлийн хяналтын төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 10.7.1.эрдэс баялгийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд тавигдах улсын хяналтыг хэрэгжүүлэх;
- 10.7.2.энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-т заасан этгээд эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан эсэх, хяналт шалгалтын тоон мэдээлэл, хариуцлага тооцсон аж ахуйн нэгжийн бүртгэл, жагсаалт, оногдуулсан хариуцлагыг нууцлалын холбогдох зохицуулалтад нийцүүлэн мэдээлэх;
- 10.7.3.төрийн захирагааны төв болон бусад төрийн захирагааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт, шалгалт хариуцсан нэгж нь байгууллагад энэ хуулийн хэрэгжилтийг хангагдаж байгаа эсэхийг хянана.
- 10.8.Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан нийгмийн даатгалын төв байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 10.8.1.энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-т заасан хуулийн этгээдээс төвлөрүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл болон ажиллах хүчиний тоог нийтэд цахимаар тогтмол мэдээлэх.
- 10.9.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 10.9.1.эрдэс баялгийн салбарт нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь, ажиллах байршил, холбогдох зөвшөөрөл, төлбөрийн мэдээллийг нийтэд цахимаар тогтмол мэдээлэх.

### **11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг**

- 11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 11.1.1.эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн санд анхан шатны тайлан гаргагчаар бүртгүүлэх;
- 11.1.2.олборлох үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдээс хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, урамшуулал болон хандив дэмжлэгийн мэдээллийг нийтэд цахимаар тогтмол мэдээлэх;
- 11.1.3.тухайн орон нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагч, олборлох үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдтэй дараах гэрээг заавал байгуулж, хэрэгжилтийг дүгнэн цахимаар нийтэд тогтмол мэдээлнэ:
- 11.1.3.a.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйл, Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17-д заасан гэрээ;
- 11.1.3.б.газар, ус ашиглах тухай гэрээ;
- 11.1.3.в.шаардлагатай нөхцөлд бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах гэрээ байгуулах.

### **12 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүрэг**

- 12.1.Эрдэс баялгийн салбарын төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 12.1.1.эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн санд анхан шатны тайлан гаргагчаар бүртгүүлэх;
- 12.1.2.дараах мэдээллийг нийтэд цахимаар тогтмол мэдээлэх;
- 12.1.2.a.санхүү, техникийн нөөц, чадавхи, сайжруулах төлөвлөгөө;

12.1.2.б.төсвийн зарцуулалтыг батлагдсан маягтын дагуу тайлагнах, тухайн зарцуулалттай холбоотой төрийн өмчит компанийн хамаарал бүхий компанийн бүтцийн зураглалыг, тайлбарын хамт;

12.1.2.в.санхүүгийн аудитын тайлан болон санхүүгийн үндсэн баримт;

12.1.2.г.ханган нийлүүлэлт, засаглал, урамшуулал, үйл ажиллагааны бодлого, журам, зардал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, томилогдсон огноо, харьяалал, албан тушаал, үүрэг, ёс зүйн дүрэм журам;

12.1.2.д.зээл, зээлийн баталгаа, үнэт цаас гаргах шийдвэр, хэмжээ, нөхцөл, эргэн төлөх хуваарь.

**Тайлбар:** “хамаарал бүхий” гэж Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно.

### **13 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн эрх үүрэг**

13.1.Энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-т зүйлд заасан хуулийн этгээд дор дурдсан нийтлэг эрх хэмжээтэй байна:

13.1.1.эрдэс баялгийн ил тод байдлын мэдээллийн санд анхан шатны тайлан гаргагчаар бүртгүүлэх, энэ хуульд заасан журмын дагуу ил тод байдлын анхан тайланг хуульд заасан хугацаанд холбогдох маягтын дагуу гаргах;

13.1.2.анхан шатны тайланг гаргахдаа шаардлагатай тайлбар, тодруулгыг өгөх, холбогдох материалыг хавсаргах;

13.1.3.Үндэсний зөвлөл, түүний ажлын алба болон тайлан нэгтгэгчээс тавьсан тодруулгын хариуг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргах, шаардлагатай мэдээллийг хамаарал бүхий нэгж, салбар, толгой, охин компаниар гаргуулах;

13.1.4.анхан шатны тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа, тодруулга, мэдээллийг тайлан нэгтгэгч, Үндэсний зөвлөл, ажлын албанаас авах хүсэлт гаргах, уг туслалцааг үнэ төлбөргүй авах;

13.1.5.эрдэс баялгийн мэдээллийн санд өгч, баталгаажуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

13.1.6.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх;

13.1.7.эрдэс баялгийн мэдээллийн санд мэдээллээ гаргахаар бүртгүүлэх этгээд нь бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө;

13.1.8.нэгдсэн тайлангийн хувийг авах, уг тайланг үйл ажиллагаандaa ашиглах;

13.1.9.анхан шатны тайланг хүргүүлэхдээ компанийн Дүрэмд заасан эрх бүхий этгээдээр баталгаажуулах;

13.1.10.газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэсний орлого, мэдээлэл, тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл, тээвэрлэсэн бүтээгдэхүүн, тоо хэмжээ, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани, төрийн байгууллагыг нийтэд мэдээлэх;

13.1.11.тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбарыг нийтэд мэдээлэх;

13.1.12.тухайн компанийн эцсийн эзэмшигч, хамаарал бүхий компанийг бүтцийн зураглал, тайлбарын хамт ил болгох.

**Тайлбар:** энэ хуулийн 13.1.9-д заасан “баталгаажуулах” гэдэг нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1, 4.1.2-т заасны дагуу тайланг цахим гарын үсгээр баталгаажуулахыг хэлнэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

#### **ЭРДЭС БАЯЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

##### **14 дүгээр зүйл.Эрдэс баялгийн мэдээллийн санг бүрдүүлэх үүрэг**

14.1.Дараах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд эрдэс баялгийн мэдээллийн санг бүрдүүлэх үүрэгтэй:

14.1.1.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны төв болон 10 дугаар зүйлд заасан төрийн захиргааны байгууллага;

14.1.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар;

14.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага;

14.1.4.Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.8 болон 5.3.15-д заасан тусгай сан, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулах төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн орлогоос бүрдүүлсэн бусад сан;

14.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч;

14.1.6.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12, 4.1.13, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.1, 8.1, 9.1-т заасан этгээд, Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан этгээд, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд;

14.1.7. ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн хувийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авах хуулийн этгээд;

14.1.8. ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, эрэл, ашиглалтын үйл ажиллагаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар төрийн байгууллагад хүсэлт гаргасан хуулийн этгээд;

14.1.9. төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын нийлбэр дүнгээр тухайн санхүүгийн жилд гарсан үйл ажиллагааны зардлын тав ба түүнээс дээш хувьтай тэнцэх үнийн дун бүхий хамтран ажиллах нэг ба түүнээс дээш гэрээ байгуулсан эсхүл адил хэмжээний үнэ бүхий бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулсан хуулийн этгээд;

14.1.10. төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын тухайн санхүүгийн жилд олсон борлуулалтын орлогын тав ба түүнээс дээш хувьтай нь тэнцэх үнийн дун бүхий бараа, бүтээгдэхүүн, эд хөрөнгө, үйлчилгээг тухайн төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагаас худалдаж авсан хуулийн этгээд;

14.1.11. байгаль орчны нөхөн сэргээлт хийх, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зорилгоор зохион байгуулагдсан Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөл, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршоо;

14.1.12. энэ хуулийн 14.1.5-14.1.7, 14.1.9-14.1.11-д заасан этгээдэд хувьцааны хэлбэрээр хөрөнгө оруулагч.

14.1.13. Үндэсний зөвлөлийн шийдвэрээр тогтоосон бусад этгээд.

### **15 дугаар зүйл. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сан**

15.1. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд хэрэглэхэд хялбар, мэдээлэл суурилсан тооцоолол, тоон мэдээллийн дун шинжилгээ, нэгтгэлийг автоматаар хийх боломжтой байна.

15.2. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн мэдээлэл нь тоон мэдээлэл, өгөгдэл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, график, бичгийн хэлбэртэй байна. Энэ зүйлд заасан кадастрын зурган мэдээлэл нь Засгийн газраас баталсан солбицол, өндрийн тогтолцоонд, өмчлөлийн бүтцийн зураглал нь Үндэсний зөвлөлийн баталсан загварт үндэслэгдэнэ.

15.3. Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, эрх бүхий этгээд баталгаажуулах ажлыг тайлан, мэдээлэл гаргагч цахимаар гүйцэтгэнэ.

15.4. Ажлын алба нь 14.1-т заасан этгээдийн мэдээлэл, бүртгэлийг цахим хэлбэрт оруулсныг нягтлах, шалгах, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, баталгаажуулах, мэдээллийн сангийн байнгын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хариуцан, мэдээллийн сангийн уялдаа холбоо, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангаж ажиллана.

15.5. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сан нь төрийн өмч байна.

15.6. Энэ хуульд заасан журамд мэдээллийн нууцлалыг хадгалахаар заасан эсхүл Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.1-т заасан нууцын зэрэглэл тогтоосоноос бусад эрдэс баялгийн мэдээллийн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй, мэдээллийн сангаас ашиглах мэдээлэл үнэ төлбөргүй байна.

### **16 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл**

16.1. Эрдэс баялгийн мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

#### **16.1.1. Эрх зүйн болон төсвийн холбогдох мэдээлэл:**

16.1.1.а. эрдэс баялгийн салбарыг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын шинэчлэл болон холбогдох төрийн байгууллагын хариуцах чиг үүрэг, тэдгээрийн өөрчлөлт;

16.1.1.б. эрдэс баялгийн салбарын нөөц боломж, орлого, зардал, татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, урамшуулал болон хандив дэмжлэгийн мэдээлэл;

16.1.1.в. эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэл, төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл;

16.1.1.г. эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж, таамаглал, тооцоолол;

16.1.1.д. төсвийн бодлого, төсвийн хуваарилалтын түвшин, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжин эсвэл орон нутгийн төсөвт шууд шилжсэн шилжүүлгийн мэдээлэл;

16.1.1.е. тусгай зөвшөөрлийн төрлийн талаарх тайлбар, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, , аж ахуйн нэгжид тавигдах техникийн болон санхүүгийн шалгуур, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, цуцлах үйл явц, холбогдох зохицуулалтын мэдээлэл,

16.1.1.ё. олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж болох газрын кадастрын мэдээлэл, талбайн солбицол, түүнийт тодорхойлох журам, холбогдох шийдвэр, тайлбар, өөрчлөлтийн мэдээлэл;

16.1.1.ж. төрөөс эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, үйл явцын баримт;

16.1.1.3.эрдэс баялгийн салбарын орлогын хуваарилалт, зарцуулалтын мэдээ; 16.1.1.и.Эцсийн эзэмшигчийн мэдээллийг бүрдүүлэх талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ил тод болгох үйл явцын талаарх мэдээлэл.

#### **16.1.2.тусгай зөвшөөрлийн бүртгэлийн мэдээлэл:**

16.1.2.а.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, шинээр олгосон, шилжүүлсэн, түдгэлзүүлсэн, цуцалсан, маргаантай тусгай зөвшөөрлийн дугаар, төрөл, ашиглалтын тусгай зөвшөөрөлд холбогдох бүтээгдэхүүний төрөл, талбайн хэмжээ, байршил, солбицол, үйлдвэрлэл эрхлэх эрх, сонгон шалгаруулалттай холбогдох мэдээлэл, сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжийн жагсаалт, шалгараагүй болон шалгарсан үндэслэл тайлбар, өөрчлөлтийн мэдээлэл,

16.1.2.б.хуулийн этгээдэд хийсэн магадлан баталгаажуулалтын мэдээлэл;

16.1.2.в.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасан, олгосон, шилжилт хөдөлгөөн хийгдсэн, дуусах огноо, өргөдөл дурдсан талбайн байршил, солбицол, талбайн нэр, хэмжээ;

16.1.2.г.тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх, цуцлахтай холбоотой хууль тогтоомжийн зөрчил, маргааны мэдээлэл.

*Тайлбар: энэ зүйлд заасан “талбайн нэр” гэж Геодези, зураг зүйн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалтад заасныг ойлгоно.*

#### **16.1.3.гэрээний мэдээлэл:**

16.1.3.а.газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул ба олборлолтой холбоотой төрийн байгууллага нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний жагсаалт, гэрээ, нэмэлт өөрчлөлт, гэрээний хавсралт;

16.1.3.б.орон нутагт аж ахуйн нэгжийн байгуулсан гэрээний жагсаалт, гэрээ, нэмэлт өөрчлөлт, гэрээний хавсралт;

16.1.3.в.газрын тосны бүтээгдэхүүн хуваах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан;

16.1.3.г.ашигт малтмалын болон эрдэс баялгийн салбарт үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл түрээсэлсэн, барьцаалсантай холбоотой гэрээ, нэмэлт өөрчлөлт, гэрээний хавсралт арилжааны зээлийн нөхцөлтэй харьцуулсан харьцуулалт;

16.1.3.д.байгаль орчин, нийгмийн нөлөөллийн холбогдох үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, хэрэгжилтийн тайлан, дүгнэлт;

16.1.3.е.Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагааны тэмдэглэл, гэрээний дагалдах хуудас.

#### **16.1.4.Эцсийн эзэмшигчийн мэдээлэл:**

16.1.4.а.аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигч болон эцсийн эзэмшигчийн бүтэн нэр, бүртгэлтэй нэрийн товчлол, иргэншил, улсын бүртгэлийн дугаар, үндэсний биеийн байцаалтын дугаар, яс үндэс, оршин суух ба ажлын газрын хаяг, харьялагдах улс, эзэмшил, өмчлөлийн хувь хэмжээ, хуулийн этгээдийг удирдан, эрх мэдэл хэрэгжүүлэх хэлбэр, албан тушаал, бусдын өмнөөс эрх хэрэгжүүлж байгаа эсэх тодруулга, холбогдох утас;

16.1.4.б.улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн огноо, албан тушаал, харьяалал;

16.1.4.в.аж ахуйн нэгжийн эцсийн эзэмшигчийн мэдээллийн бүтцийн зураглал ба тайлбар, төрийн эзэмшил дэх хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаасны хувь хэмжээ;

#### **16.1.5. хайгуул, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн мэдээлэл**

16.1.5.а.тухайн жилд явагдсан хайгуул үйл ажиллагааны мэдээлэл, түүхий эд, бүтээгдэхүүн баяжуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, өртөг, дундаж үнэ, тооцооллын эх сурвалж болон аргачлалын мэдээлэл;

#### **16.1.6.экспортын мэдээлэл**

16.1.6.а.экспортын төлөвлөгөө, бодит экспортын хэмжээ, түүхий эд, аж ахуйн нэгж, төсөл бүрээс олсон нийт орлого, түүхий эдийн үнэ, тооцооллын эх сурвалж болон аргачлалын мэдээлэл;

#### **16.1.7.татвар, төлбөр, хураамж, гүйлгээ**

16.1.7.а.олборлох салбарын татвар, хураамж, төлбөр, тусгай зориулалтын сангийн орлогын хуваарилалтыг аж ахуйн нэгж, төсөл бүрээр;

16.1.7.б.Засгийн газрын газрын хүлээн авах ашигт газрын тос, хувьцааны ногдол ашиг, бусад томоохон хэмжээний орлого болон материаллаг үр шим, төрийн өмчтэй аж ахуйн нэгж хооронд болон бусад төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй төлбөр;

16.1.7.в.холбогдох албан татвар;

16.1.7.г.нөөцийн төлбөр;

16.1.7.д.гарын үсгийн, хайгуулын ажлын, үйлдвэрлэлийн болон бусад төлбөр, дэмжлэг, шагнал, урамшууллын мэдээлэл;

- 16.1.7.е.тусгай зөвшөөрлийн төлбөр, түрээсийн төлбөр, лиценз болон гэрээтэй холбоотой бусад төлбөр, хууль тогтоомж зөрчсөнөөр бий болсон зөрүү;
- 16.1.7.ё.төлбөр, бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцон ханган нийлүүлэх, зээл, тусламж олгох, дэд бүтэц барих зэрэг үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр, төлбөр, орлого;
- 16.1.7.ж.ус, газар, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөр, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журмын 4.1.4-т заасны дагуу төвлөрүүлсэн мөнгөн дүн, баримт;
- 16.1.7.з.газрын төлбөр, холбогдох мэдээлэл;
- 16.1.7.и.усны болон ус бохирдуулсны төлбөр, холбогдох мэдээлэл;
- 16.1.7.й.үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого;
- 16.1.7.к.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийгмийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл.

#### **16.1.8.аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

- 16.1.8.а.бүтээгдэхүүн, түүхий эд тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, тээвэрлэлтэд оролцогч хуулийн этгээдийн мэдээлэл;
- 16.1.8.б.тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, хураамж болон тэдгээрийг тооцох аргачлал, тайлбар;
- 16.1.8.в.газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлого;
- 16.1.8.г.борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, үнэ, борлуулалтын хэлбэр, орлого, худалдан авагчийн нэр, харьяалал;
- 16.1.8.д.худалдан авагчийг сонгон шалгаруулах нөхцөл;
- 16.1.8.е.терийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэнд өгсөн хандив, тусламж, зэрэг татварын бус төлбөрийн талаарх мэдээлэл, хэмжээ, зориулалт;
- 16.1.8.ё.ундны болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны зөвшөөрөгдсөн ба хэрэглэсэн хэмжээ, дахин ашигласан ус, байгаль орчны нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээлэл;
- 16.1.8.ж.нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн хэмжээ, тусгай санд төвлөрүүлсэн огноо, зарцуулалтын талаарх мэдээлэл;
- 16.1.8.з.эд хөрөнгийн болон эрхийн барьцааны талаарх мэдээлэл;
- 16.1.8.и.гадаад болон Монгол Улсын ажиллах хүч, орон нутгийн иргэдийн ажлын байрны мэдээлэл, хүйс, боловсрол, албан тушаалын ангиллаар.

*Тайлбар: “борлуулах хэлбэр” гэж мөнгөн хэлбэр эсхул свол гэрээ, нөөцөөр баталгаажсан зээл зэрэг борлуулах нөхцөлийг тодорхойлохыг хэлнэ.*

#### **16.1.9.Орон нутгийн төлбөр, нийгмийн хариуцлага, хандив, тусламж**

- 16.1.9.а.эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн мэдээлэл нь арван хоёроос доошгүй жилийн хугацаанд ил тод, нээлттэй байж, хадгалагдана.
- 16.1.9.б.төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн;
- 16.1.9.в.орон нутгийн гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл.

- 16.2. Үндэсний зөвлөлийн шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

#### **17 дугаар зүйл. Мэдээллийн аюулгүй байдал**

- 17.1.Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн мэдээлэл нь тод байгууллагын 18 дугаар зүйлд заасан онцгой нөхцөлтэй холбоотой тохиолдолд мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.
- 17.2.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан онцгой нөхцөлтэй холбоотой тохиолдолд мэдээллийг ил тод болгохгүй байх хүсэлтийг гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд Үндэсний зөвлөл үндэслэлийг харгалзаж тухайн мэдээллийг тодорхой хугацаанд ил тод болгохгүй байх арга хэмжээг хэсэгчлэн авч болно. Хуулийн этгээдийн мэдээллийг тодорхой хугацаанд нууцлах нөхцөл нь хуулийн этгээдийг мэдээллийн санд мэдээллээ гаргахгүй байх үндэслэл болохгүй.
- 17.4.Иргэн, хуулийн этгээд эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангаас мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр авах хүсэлт гаргасан бол зардлыг Үндэсний зөвлөлийн тогтоосноор тооцож төлүүлнэ.

*Тайлбар: “мэдээлэл өгөх зардал” гэж мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх зорилгоор хувилах, олишуулах, шуудангаар хургуулэх болон бусад шаардлагатай зардлыг хэлнэ.*

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

#### **ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА САНХҮҮЖИЛТ, ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН**

#### **18 дугаар зүйл. Үндэсний зөвлөл**

- 18.1.Эрдэс баялгийн салбарт ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий Үндэсний зөвлөл хангаж ажиллана.

18.2. Зөвлөлийг тэргүүлэх албан тушаалтан болон зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

18.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын бүртгэл, татвар, гааль ашигт малтмал, газрын тос, цөмийн энергийн байгууллага, Авлигатай тэмцэх газрын төлөөллийг жендерийн тэгш байдлыг хангаж оролцуулна.

18.4. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ хуулийн 18.3-т заасан төлөөллөөс гадна тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 11, иргэний нийгмийн эвслийн 11 гишүүний төлөөллийг жендерийн тэгш байдлыг хангаж оролцуулна.

18.5. Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 14.1-т заасан этгээдээс энэ хуулийн 21.1.1-21.1.2-т заасан тайланг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулах, ажлын уялдааг хангах санал боловсруулах, Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий бие даасан ажлын албатай байна.

18.6. Ажлын албаны харьялал, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг Үндэсний зөвлөл, үйл ажиллагааны төсвийг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу батална.

18.7. Энэ хуулийн 18.4-т заасан Үндэсний зөвлөлийн гишүүнээр оролцох хуулийн этгээд, иргэний нийгмийн төлөөллийг олон нийтэд ил тод зарлах, төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулах, оролцоог эрх тэгш бүрдүүлэх нөхцөлийг ажлын алба хангаж ажиллана.

18.8. Үндэсний зөвлөл нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын тэнцүү төлөөллөөс бүрдсэн эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг орон нутагт хэрэгжүүлэх салбар зөвлөлийг байгуулж болно.

18.9. Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилно.

18.10. Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.

*Тайлбар: "салбар зөвлөл" гэж эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллага, хуулийн этгээдийн тэнцвэртэй төлөөллөөс бүрдсэн, Үндэсний зөвлөлөөс томилогдсон салбарыг ойлгоно.*

## 19 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэн эрх

19.1. Үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1. хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 2 дугаар улиралд багтаан Засгийн газар, олон нийтэд мэдээлнэ.

19.1.2. эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллага хоорондын зохистой харилцаа, хамтын ажиллагааг дэмжих;

19.1.3. эрдэс баялгийн салбарын ил тод байдлын мэдээллийн сан, тайлан болон өргөдөл, гомдолын агуулгад судалгаа хийлгэх, дүгнэлт гаргуулах, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах;

19.1.4. эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх шаардлагатай арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах;

19.1.5. анхан шатны тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах;

19.1.6. иргэд, хувийн хэвшил, төр болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах;

19.1.7. эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой санал боловсруулж, төрийн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;

19.1.8. энэ хуулийн 24 дугаар зүйлд заасан нэгдсэн тайланг гаргах ажлыг зохион байгуулах, нэгдсэн тайланг баталж тайланг олон нийтэд мэдээлэх;

19.1.9. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, тайлан нэгтгэгчийн үйл ажиллагаа болон эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах;

19.1.10. ажлын албаар дамжуулан анхан шатны тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа, тодруулга, мэдээллийг анхан шатны тайлан гаргагч, тайлан нэгтгэгч, иргэн, хуулийн этгээдэд үнэ төлбөргүй өгөх;

19.1.11. энэ хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа анхан шатны тайлан гаргагч тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагыг олон нийтэд сурталчлах;

19.1.12. эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах журам, заавар, маягт, зөвлөмж батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.

19.2. Энэ хуулийн 22.5-д заасан эрх бүхий этгээд анхан шатны тайланг баталгаажуулаагүй бол ажлын алба хүлээн авахаас татгалзах эрхтэй.

19.3. Үндэсний зөвлөл, түүний ажлын алба, тайлан нэгтгэгчийн үйл ажиллагаанд хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлэх, саад учруулахыг хориглоно.

19.4.Үндэсний зөвлөлийн шийдвэрээр анхан шатны тайлан гаргагч төрийн байгууллагын жагсаалтыг шинэчилж болно.

19.5.Хуулийн этгээд нь тайлан гаргах сүүлийн өдрөөс өмнө эсхүл хууль тогтоомжид заасан хугацааны дотор хүндэтгэн үзэх шалтгаанаар анхан шатны тайлан болон олон нийтэд ил тод мэдээлэх бусад мэдээллийг гаргах боломжгүй болсон тухайгаа Үндэсний зөвлөлд мэдэгдсэн бол уг асуудлын мөн чанарыг тогтоох зорилгоор Үндэсний зөвлөл нь тухай хуулийн этгээдийн тайлбарыг гаргуулах, зөрчил үүсэх үндэслэлийг хойшлуулах эрхтэй.

19.6.Нэгдсэн тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах.

#### **20 дугаар зүйл.Ил тод байдлын тайлан**

20.1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан нь дор дурдсан төрөлтэй байна:

20.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын анхан шатны тайлан;

20.1.2.төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайлан;

20.1.3.нэгдсэн тайлан

20.2.Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан анхан шатны тайлангийн маягтыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Үндэсний статистикийн хороо нь дараах загвараар батална:

20.2.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн гаргах анхан шатны тайлангийн маягт;

20.2.2.төрийн байгууллагын анхан шатны тайлангийн маягт;

20.2.3.хуулийн этгээдийн анхан шатны тайлангийн маягт.

20.3.Үндэсний статистикийн хороо нь анхан шатны тайлан гаргагч төрийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоос хамаарч Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн зарим төрийн байгууллагын гаргах тайланд нэмэлт мэдээлэл тусгахаар тайлангийн маягтыг баталж болно.

#### **21 дүгээр зүйл.Төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайлан**

21.1.Төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайланг энэ хуулийн 9-11 дугаар зүйлд заасан төрийн байгууллага гаргана.

21.2.Сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 20.2.1-д заасан маягтаар сум, дүүргийн өмнөх жилийн анхан шатны тайланг гарган, дөрөвдүгээр сарын 15-ны дотор мэдээллийн санд оруулсан байна.

21.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргийн анхан шатны тайлангийн мэдээллийг нэгтгэн баталгаажуулж, аймаг, нийслэлийн тухайн жилийн анхан шатны тайланг гарган, тавдугаар сарын 01-ний дотор мэдээллийн санд оруулсан байна.

21.4.Энэ хуулийн 9-11 дүгээр зүйлд заасан этгээд нь анхан шатны тайлангийн мэдээллийг энэ хуулийн 20.2.2-т заасан маягтаар тухайн жилийн анхан шатны тайланг гарган, тавдугаар сарын 15-ны дотор мэдээллийн санд оруулсан байна.

21.5.Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.

21.6.Төрийн байгууллагын тайлан гаргагч бүр тус бүрийн гаргасан ил тод байдлын тайланд туссан мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

#### **22 дугаар зүйл.Хуулийн этгээдийн ил тод байдлын анхан шатны тайлан**

22.1.Энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-д заасан этгээд нь энэ хуулийн 20.2.3-т заасан маягтаар хуулийн этгээдийн өмнөх жилийн анхан шатны тайланг гарган, дөрөвдүгээр сарын 15-ны дотор мэдээллийн санд оруулсан байна.

22.2.Төрийн болон орон нутгийн өмчйт, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь анхан шатны тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувиар гаргана.

22.3.Анхан шатны тайлан гаргагч нь тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх эсхүл тухайн жилд үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамаарч, энэ хуулийн 14.1.3, 14.1.5-14.1.11-д заасанд нийцэх нөхцөлд анхан шатны тайланг жил бүр гаргана.

22.4.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан журмын дагуу эрх авсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх бүхий нөхөрлөлөөс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь анхан шатны тайланг аудиталсан санхүүгийн тайланд үндэслэн гаргана.

22.5.Анхан шатны тайлан гаргагч хуулийн этгээдийн Дүрэмд тодорхойлсон эрх бүхий этгээд анхан шатны тайлангийн мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулж, гарын үсэг зуран, хариуцлага хүлээнэ.

#### **23 дугаар зүйл.Иргэний нийгмийн эвслийн ил тод байдлын тайлан**

23.1.Эрдэс баялгийн салбар болон ил тод байдлыг хангах, засаглал, авлига болон ашиг, сонирхлын зөрчлийг бууруулах чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн холбоо, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцож болно.

23.2.Үндэсний зөвлөлийн иргэний нийгмийн эвслийн төлөөлөлд нэр дэвшигч нь иргэний нийгмийн эвслийн ил тод байдлын тайлан гаргах бөгөөд доор дурдсан мэдээллийг тусгана:

23.2.1.гишүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

23.2.2.санхүүжилтийн талаарх мэдээлэл, хэмжээ;

23.2.3.үйл ажиллагааны чиглэл, эрдэс баялгийн салбарын засаглалын чиглэлээр тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээ;

23.2.4.тайлан гаргагч хуулийн этгээд, төрийн байгууллагатай байгуулсан гэрээний талаарх мэдээлэл.

23.3.Ил тод байдлын тайлан гаргаагүй төрийн бус байгууллагын нэр дэвшигчийг ажлын алба иргэний нийгмийн эвслийн төлөөлөөр бүртгэхгүй.

23.4.Үндэсний зөвлөлийн иргэний нийгмийн эвслийн төлөөлөлд батлагдсан төрийн бус байгууллага нь эрдэс баялгийн салбарын засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, олборлох үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдээс хүлээн авсан хандив дэмжлэг, гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлого, зарлагын мэдээлэл бүхий Үндэсний зөвлөлийн баталсан ил тод байдлын тайланг жил бүрийн тавдугаар сарын 15-ны дотор гарган, Үндэсний зөвлөлийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийн хамт ажлын албанд хүргүүлнэ.

#### **24 дүгээр зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайлан**

24.1.Үндэсний зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн Нээлттэй тендэр сонгон шалгаруулалтын журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж, эрдэс баялгийн ил тод байдлын нэгдсэн тайлан гаргах тайлан нэгтгэгчийг сонгоно.

24.2.Ажлын алба энэ хуулийн 21.1 болон 22.1-д заасан тайланг тайлан нэгтгэгчид хүргүүлсэнээс хойш гурван сарын дотор тайлан нэгтгэгч нь тайланг тулган нэгтгэх ажлыг гүйцэтгэж, нэгдсэн тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

24.3.Үндэсний зөвлөл нь нэгдсэн тайланг дараа оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэж, хуралдаанд оролцогчдын олонхын саналаар батлан олон нийтэд мэдээлэл ба батлагдсан нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газарт хүргүүлнэ.

24.4.Нэгдсэн тайланд энэ хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан тайлангийн тэнцлийг тусгахаас гадна дор дурдсан мэдээллийг тусгана:

24.4.1.улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ;

24.4.2.эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай;

24.4.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа орд тус бүрээр олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ;

24.4.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;

24.4.5.ил тод байдлын тайлан ирүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;

24.4.6.ил тод байдлын тайланг нэгтгэх явц болон эрдэс баялгийн салбарын ил тод байдал, засаглалыг сайжруулах талаар нэгтгэгчийн зүгээс гаргасан дүгнэлт, зөвлөмж; түүний хэрэгжилтийн мэдээлэл;

24.4.7.ил тод байдлын тайлангууд хоорондын зөрүүг илрүүлэх ажиллагааны үр дүн, танилцуулга;

24.4.8.тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төр, төрийн бус байгууллагад өгсөн хандив, тусlamжийн дүн;

24.4.9.нэгдсэн тайлангийн маягтад заасан бусад мэдээлэл.

24.5.Үндэсний зөвлөлөөс нэгдсэн тайлангийн төслийг хангалтгүй гэж үзвэл тайланг ажлын албанд буцаах бөгөөд ажлын алба нь нэгдсэн тайланг эцэслэн боловсруулах ажлыг тайлан нэгтгэгчээр гүйцэтгүүлнэ.

24.6.Тайлан нэгтгэгч нь нэгдсэн тайлангийн талаар Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, шүүмжлэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж нэгдсэн тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор эцэслэн ажлын албанад хүргүүлнэ. Ажлын алба нь эцэслэн боловсруулсан нэгдсэн тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна.

24.7.Ажлын алба Үндэсний зөвлөлөөс батлагдсан нэгдсэн тайланг хэвлэн олшруулах, ажлын албаны цахим хуудсанд байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

*Тайлбар: энэ зүйлд дурдсан тайлан нэгтгэгч гэж Монгол Улсын эсхүл гадаад улсын эрх бүхий этгээдээс аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, захиалагч байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн этгээдийг ойлгоно.*

#### **25 дугаар зүйл.Ил тод байдлын анхан шатны тайлан хоорондын зөрүүг хянан шийдвэрлэх**

25.1.Тайлан нэгтгэгч нь анхан шатны тайланг нэгтгэх явцад тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон төрийн байгууллагаас тэдгээрийн гаргасан анхан шатны тайланд тусгасан мэдээллийг тодруулах, нэмэлт мэдээлэл авах эрхтэй.

25.2.Тайлан нэгтгэгч нь энэ зүйлийн 25.1-д заасан хүсэлтийг тухайн тайлан гаргасан хуулийн этгээдэд албан бичгээр, үүссэн зөрүүний талаар дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүргүүлнэ.

25.3.Энэ зүйлийн 25.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан хуулийн этгээд хариуг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор тайлан нэгтгэгчид бичгээр хүргүүлнэ.

25.4.Тайлан нэгтгэгч нь энэ зүйлийн 25.3-т заасан хариуг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн тухай ажлын 10 хоногийн дотор хариу ирүүлсэн хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Шаардлагатай тохиолдолд тайлан гаргагч хуулийн этгээд нь зөрүү үүсгэж байгаа нөгөө талын тайлан гаргагчийн тайлантай танилцаж болно.

25.5. Тайлан нэгтгэгч нь энэ зүйлийн 25.3-т заасан мэдээлэлд үндэслэн тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг нэгдсэн тайлангийн төсөлд тусгах бөгөөд хэрхэн тусгасан талаар анхан шатны тайлан гаргасан хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

25.6. Анхан шатны тайлан гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, эсхүл төрийн байгууллагаас энэ зүйлийн 25.3-т заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол тайлан нэгтгэгч нь энэ талаар ажлын албан дутхай бүр мэдэгдэнэ.

25.7. Анхан шатны тайлан гаргасан хуулийн этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд ажлын алба нь холбогдох зөвлөмж, мэргэжлийн арга зүйгээр ханган, уг тайлан гаргагчийг сургалтад хамруулж болно.

25.8. Ажлын алба нь шийдвэрлэгдээгүй зөрүүг шалгуулахаар эрх бүхий байгууллагад нэгдсэн тайлан батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор хандаж, мэдэгдэнэ.

## **26 дугаар зүйл. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт**

26.1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

26.2. Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагааны жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг зардлын төслийг багцдаа тусган зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

26.3. Салбар зөвлөлийн төсвийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсөвт тусган санхүүжүүлнэ.

26.4. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын санхүүжилт нь бие даасан, хараат бус үйл ажиллагааг явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд хүрэлцээтэй байна.

26.5. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллага нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хэрэгжилтийг дэмжих зорилгоор энэ хуулийн 14.1-т заасан ил тод байдлын анхан шатны тайлан гаргах үүрэг хүлээгээгүй иргэн, хуулийн этгээд, гадаад улс, олон улсын байгууллагаас зээл, хандив, тусламж авч болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **27 дугаар зүйл. Гомдол хянан шийдвэрлэх**

27.1. Анхан шатны тайлан гаргагч, иргэн, хуулийн этгээд нь захирагааны журмаар дараах харьяаллаар гомдол гаргаж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй:

27.1.1. ажлын алба, салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Үндэсний зөвлөлийн даргад;

27.1.2. Үндэсний зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Засгийн газарт;

27.1.3. ёс зүйн зөрчилтэй холбогдох гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлд.

27.2. Энэ хуулийн 27.1-т заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

27.3. Үндэсний зөвлөлийн баталсан дүрэм, журам, шийдвэртэй холбогдох гомдлыг шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

27.4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд Иргээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалт, 16 дугаар зүйлд заасан хугацааг баримтална.

### **28 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

28.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2. Доор дурдсан зөрчилд холбогдуулж Захирагааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ:

28.2.1. төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийн нууцыг задруулсан;

28.2.2. хуульд заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй.

28.3. Энэ хуулийн 28.2-т заасан зөрчлийн улмаас хуулийн этгээдэд хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна.

28.4. Энэ хуулийг зөрчсөн хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрх бүхий байгууллагын албан тушаалтан үүссэн нөхцөл байдал, зөрчлийг харгалзан дор дурдсан арга хэмжээг авна:

28.4.1. ажлын 10 хоногийн хугацаанд дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

28.4.2. эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 28.4.1-т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагаыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.5. Энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан арга хэмжээ авсан талаар ажлын алба нь зөрчил тогтоогдсоноос хойш хуанлийн 30 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

28.6. Энэ хуулийн 28.5-д зааснаар мэдээллийг олон нийтэд мэдэгдэх нь тухайн зөрчил гаргасан хуулийн этгээдийн санхүү, үнэлгээ, хувьцааны ханшид сөрөг нөлөө үзүүлэхүйц ноцтой эсхүл эрсдэлтэй гэж үзвэл хүндэтгэн үзэх шалтгаанд тооцож болно. Хуулийн этгээд нь зөрчил гаргасныг тогтоосноос хойш ажлын 10 хоногийн дотор ажлын албанад хүсэлт гаргаж хүндэтгэн үзэх шалтгаанаар мэдээллийг олон нийтэд дэлгэх эсэх асуудлыг Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлүүлнэ.

**29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

29.1. Энэ хуулийг 202... оны .... сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.